



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2026/075/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитор: П.Санчиргарав
Утас: 70533552 Цахим хаяг: Sanchirgaravp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539. Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 249

танай _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД
СУМЫН 29 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БОЛОРЦЭРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын 29 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нягтлан бодогч солигдоход тооллого хийгээгүй, гэрээ байгуулаагүй ажилд санхүүжилт олгосон, хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас хэтрүүлэн зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 891,770.0 мянган төгрөгөөр цэцэрлэгийн барилгад их засварын ажлыг капиталжуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзан,

4628950379

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 124,775.9 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 152,105.5 мянган төгрөгийн нутгийн дэмийн урамшуулал, 50,418.9 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 327,301.3 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 9 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 90.0 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЧӨСӨХБАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	356,288,043.10	147,009,997.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	297,646,943.10	55,003,197.20
312	Банканд байгаа бэлэн мөнгө	297,646,943.10	55,003,197.20
3121	Төгрөг	297,646,943.10	55,003,197.20
31211	Төрийн сангийн харилцах	297,646,943.10	55,003,197.20
35	БАРАА МАТЕРИАЛ	58,641,100.00	92,006,800.00
351	Түүхий эд материал	22,116,900.00	40,954,900.00
35110	Тусгай зориулалттай материал	22,116,900.00	40,954,900.00
354	Хангамжийн материал	36,524,200.00	51,051,900.00
35410	Бичиг хэргийн материал	-	264,500.00
35420	Аж ахуйн материал	18,512,700.00	43,761,700.00
35460	Хүнсний материал	18,011,500.00	7,025,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,204,329,976.67	3,031,252,527.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,204,329,976.67	3,031,252,527.46
392	Биет хөрөнгө	2,119,954,976.67	2,946,877,527.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,008,060,132.00	2,899,830,417.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(143,023,892.40)	(176,491,561.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,546,605.00	179,635,605.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,455,608.40)	(97,113,575.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,074,450.00	178,374,450.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(59,150,112.70)	(99,066,909.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	82,803,591.00	100,803,591.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,150,187.83)	(40,344,490.11)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,250,000.00	1,250,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	84,375,000.00	84,375,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,375,000.00	84,375,000.00
413	Өглөг	2,560,618,019.77	3,178,262,524.66
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	11,005,207.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,560,618,019.77	3,167,257,317.66
51	Засгийн газрын хувь оролцоо	2,560,618,019.77	3,167,257,317.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,771,929,515.00	1,771,929,515.00
51101	Өмч: - төрийн	1,771,929,515.00	1,771,929,515.00
512	Хуримтлагдсан үр дүн	765,890,974.77	1,372,553,037.66
51210	Өмнөх үеийн үр дүн	765,890,974.77	765,913,739.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	606,639,297.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,222,646,711.36	2,519,946,960.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	913,343,596.00	1,311,382,560.30
120	Нийтлэг татварын бус орлого	913,343,596.00	1,311,382,560.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	913,343,596.00	492,263,679.30
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	590,982,528.00	942,659,285.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материа	-	36,118,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,925,618.00	332,605,275.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,435,450.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,309,303,115.36	1,208,564,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,122,123,615.36	992,864,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,122,123,615.36	992,864,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	187,179,500.00	215,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	187,179,500.00	215,700,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,511,167,277.25	1,849,675,536.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,511,167,277.25	1,849,675,536.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,451,404,158.47	1,849,675,536.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,998,142.51	1,212,748,338.88

210101	Үндсэн цалин	884,998,142.51	747,499,322.45
210102	Нэмэгдэл	00.00	402,584,276.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	27,945,000.00
210104	Урамшуулал	00.00	34,719,739.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,667,105.50	154,722,679.02
210201	Тэтгэврийн даатгал	92,762,785.22	105,090,009.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,429,341.94	12,471,207.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,632,171.07	6,230,412.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,568,561.56	6,186,208.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,274,245.71	24,744,843.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,636,381.22	148,963,707.86
210301	Гэрэл, цахилгаан	8,019,330.82	12,654,588.76
210302	Түлш, халаалт	149,567,290.40	131,485,399.10
210303	Цэвэр, бохир ус	4,049,760.00	4,823,720.00
2105	Нормативд зардал	148,515,750.00	176,908,590.00
210502	Хоол, хүнс	148,515,750.00	176,908,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,633,000.00	5,464,120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,633,000.00	5,464,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,953,779.24	145,868,101.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,019,550.00	23,435,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,000,000.00	8,591,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,934,229.24	113,840,901.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,763,118.78	61,736,292.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,220,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,220,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,543,118.78	61,736,292.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,543,118.78	61,736,292.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	711,479,434.11	670,271,423.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,895,833.31
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	00.00	1,895,833.31
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,895,833.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	711,479,434.11	606,639,297.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,582,228,733.36	1,541,169,675.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	272,925,618.00	332,605,275.00
120	Нийтлэг татварын бус орлого	272,925,618.00	332,605,275.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	272,925,618.00	332,605,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,925,618.00	332,605,275.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,309,303,115.36	1,208,564,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,122,123,615.36	992,864,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,122,123,615.36	992,864,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	187,179,500.00	215,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	187,179,500.00	215,700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,424,574,798.01	1,722,077,128.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,424,574,798.01	1,722,077,128.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,364,811,679.23	1,722,077,128.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	884,998,141.74	1,212,748,338.88
210101	Үндсэн цалин	607,306,954.94	747,499,322.45
210102	Нэмэгдэл	245,202,356.80	402,584,276.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	27,945,000.00
210104	Урамшуулал	32,488,830.00	34,719,739.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,667,106.27	154,722,679.02
210201	Тэтгэврийн даатгал	78,336,944.26	105,090,009.02
210202	Тэтгэмжийн даатгал	9,223,099.43	12,471,207.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,479,549.88	6,230,412.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,325,502.71	6,186,208.00

/төгрөгөөр/

210205	Эрүүл мэндийн даатгал	17,302,009.99	24,744,843.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,636,381.22	148,963,707.86
210301	Гэрэл, цахилгаан	8,019,330.82	12,654,588.76
210302	Түлш, халаалт	149,567,290.40	131,485,399.10
210303	Цэвэр, бохир ус	4,049,760.00	4,823,720.00
2105	Нормативд зардал	152,565,350.00	154,917,583.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	6,290,869.00
210502	Хоол, хүнс	152,565,350.00	148,626,714.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,633,000.00	5,464,120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,633,000.00	5,464,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,311,700.00	40,260,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,061,700.00	29,382,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,250,000.00	10,878,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,763,118.78	61,736,292.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,220,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,220,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,543,118.78	61,736,292.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,543,118.78	61,736,292.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	157,653,935.35	(242,643,745.90)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	157,653,935.35	(242,643,745.90)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162,517,423.11	297,646,943.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	320,171,358.46	55,003,197.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,771,929,515.00	-	(141,051,907.13)	1,630,877,607.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(12,501,000.00)	(12,501,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,771,929,515.00	-	(153,552,907.13)	1,618,376,607.87
Тайлант үеийн үр дүн	-	-	240,785,393.15	240,785,393.15
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,771,929,515.00	22,797,530.00	765,890,974.77	2,560,618,019.77
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,771,929,515.00	22,797,530.00	765,890,974.77	2,560,618,019.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	22,765.00	22,765.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,771,929,515.00	22,797,530.00	765,913,739.77	2,560,640,784.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(22,765.00)	-	(22,765.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	606,639,297.89	606,639,297.89
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,771,929,515.00	22,774,765.00	1,372,553,037.66	3,167,257,317.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Тайлант оны Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,863,520,800.00	1,722,077,128.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,863,520,800.00	1,722,077,128.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,863,520,800.00	1,722,077,128.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,268,928,800.00	1,212,748,338.88
210101	Үндсэн цалин	786,555,400.00	747,499,322.45
210102	Нэмэгдэл	462,390,800.00	402,584,276.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,945,000.00
210104	Урамшуулал	19,982,600.00	34,719,739.55

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,952,900.00	154,722,679.02
210201	Тэтгэврийн даатгал	107,195,800.00	105,090,009.02
210202	Тэтгэмжийн даатгал	12,689,300.00	12,471,207.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,344,600.00	6,230,412.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,344,600.00	6,186,208.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,378,600.00	24,744,843.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,700,000.00	148,963,707.86
210301	Гэрэл, цахилгаан	21,000,000.00	12,654,588.76
210302	Түлш, халаалт	175,900,000.00	131,485,399.10
210303	Цэвэр, бохир ус	13,800,000.00	4,823,720.00
2105	Нормативт зардал	171,951,600.00	154,917,583.00
210502	Хоол, хүнс	171,951,600.00	154,917,583.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,358,000.00	5,464,120.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,358,000.00	5,464,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,629,500.00	40,260,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,750,900.00	29,382,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,878,600.00	10,878,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,863,520,800.00	1,479,433,382.86
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,268,928,800.00	992,864,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	215,700,000.00	153,963,707.86
132001	Орон нутгийн төсвөөс	215,700,000.00	153,963,707.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	378,892,000.00	332,605,275.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	378,892,000.00	332,605,275.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	297,646,943.10
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	55,003,197.20

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122,931.3 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад 122,931.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- ✓ Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан,
- ✓ Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөрүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 113,731.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- ✓ Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн хоол хүнсний зардлыг 6,290.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- ✓ Тайлант онд 1,895.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхдээ Үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгэсэн,
- ✓ Үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг тодруулга тайлангийн цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 1,013.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар 6 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Хоол, хүнсний зардлыг 417.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", Монгол улсын Засгийн газрын 2024 оны "*Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай*" 237 дугаар тогтоолоор баталсан норм, нормативыг баримталж ажиллаагүй байна.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: 1 Нягтлан бодогч, нярав нарт 5,328.0 мянган төгрөгийн балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*хариуцлагатай байх*", 6 зүгээр зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*", 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар баталсан "*Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: 2 Түүвэрт сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн оношлогооны үйлчилгээнд 3,390.4 мянган төгрөг зарцуулахдаа гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлэгийн 1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: 3 Нягтлан бодогч солигдоход тооллого хийгээгүй, гэрээ байгуулаагүй ажилд 3,390.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 417.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 12 дугаар зүйлийн 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан үүргээ биелүүлж ажиллах сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт: 4 Зүүн бүсийн уулзалт зохион байгуулахад сургагч багшийн зардал, замын зардлыг үйл ажиллагааны чиглэл хамаарагүй "Галбын дэвшил" ХХК-д нэмэмжлэх үндэслэн шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахы хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт: Тайлант онд хоол хүнсний зардлаас 165,922.8 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нэг аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан	1	-			1	-	1	-				
Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөрүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 113,731.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	113,731.4			1	113,731.4	1	113,731.4				
Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн хоол хүнсний зардлыг 6,290.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	6,290.9			1	6,290.9	1	6,290.9				
Тайлант онд 1,895.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэхдээ Үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгэсэн	1	1,895.8			1	1,895.8	1	1,895.8				
Үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг тодруулга тайлангийн цалингийн өглөгтэй тулган баталгаажуулахад 1,013.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	1,013.2			1	1,013.2	1	1,013.2				
Дүн	5	122,931.3			5	122,931.3	5	122,931.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21,195.3 мянган төгрөгийн 3 зарлагын мөнгөн гүйлгээ, 7,219.1 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлд мэдээлэл оруулаагүй	1	28,414.4						1 28,414.4
Дүн	1	28,414.4						1 28,414.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоол, хүнсний зардлыг 417.8 мянган төгрөгөөр илүү зарцуулсан	1	417.8	1	417.8								
Нягтлан бодогч, нярав нарт балансын урамшууллыг цалингийн зардлаас олгосон	1	5,328.0			1	5,328.0						
Түүвэрт сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн оношлогооны үйлчилгээнд 3,390.4 мянган төгрөг зарцуулахдаа гэрээ байгуулаагүй	1	3,390.4			1	3,390.4						
Нягтлан бодогч солигдоход тооллого хийгээгүй, гэрээ байгуулаагүй ажилд 3,390.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон, хоол, хүнсний зардлыг тогтоосон норм нормативаас 417.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан	1	-							1	-		
Зүүн бүсийн уулзалт зохион байгуулахад сургагч багшийн зардал, замын зардлыг үйл ажиллагааны чиглэл хамаарагүй "Галбын дэвшил" ХХК-д нэмэмжлэх үндэслэн шилжүүлсэн	1	2,004.0			1	2,004.0						
Тайлант онд хоол хүнсний зардлаас 165,922.8 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нэг аж ахуйн нэгжээс худалдан авалт хийсэн	1	165,922.8					1	165,922.8				
Дүн	6	177,063.0	1	417.8	3	10,722.4	1	165,922.8	1	-		